



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/82

Хажуу шинэ үс

Хөдөө аж ахуйн салбар болон төв,
суурин газрын 2022-2023 оны өвөлжилт,
хаваржилтын бэлтгэл хангах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын засгийн газрын 2022 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 277 дугаар тогтоол, Аймгийн засаг даргын А/337 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. "Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай", 2022-2023 оны аймгийн Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, ажлын явцад хяналт тавих, хэрэгжилтийг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 2022 оны 10 дугаар сарын 10-ний дотор хангаж, тайлан мэдээг 10 дугаар сарын 15-ний дотор, төв суурин газрын бэлтгэл ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 20-ний дотор тус тус хангаж хөдөө аж ахуйн мэргэжилтэнд ирүүлэхийг, Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Засгийн газрын тогтоол, албан даалгаврыг хэрэгжүүлэх, ажил зохион байгуулах, ажлын явцад хяналт тавих, шалгуур үзүүлэлтийн дагуу хүлээн авах ажлыг 10 дугаар сарын 15-ний өдрийн дотор зохион байгуулахыг Засаг даргын орлогч (Д.Сарангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

482201082

Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 13-ний
өдрийн 12 тоот захирамжийн

Хавсралт 1



Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах
ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Сарангэрэл	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	Г.Цэгц-Яруу	(Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)
Гишүүд:	Н.Ганбат	(Санхүү албаны дарга)
	Д.Мандахцацрал	(Байгаль орчны улсын байцаагч)
	А.Бямбадорж	(Мал эмнэлгийн улсын байцаагч)
	Э.Эрдэнэчимэг	(Ус цаг уур орчны төвийн эрхлэгч)
	Б.Өлзийбат	(Улсын нөөцийн нярав)
	Б.Даваасүрэн	(3 дугаар багийн Засаг дарга)
	Г.Батчулуун	(2 дугаар багийн Засаг дарга)
	Б.Мөнхтөгөлдөр	(1 дүгээр багийн Засаг дарга)

Засаг даргын 2022 оны 09 дугаар сарын 15-ны

өдрийн 4/82 тоот захирамжийн

Хавсралт 02

Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Сарангэрэл	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	А.Алтанчимэг	(Цэцэрлэгийн эрхлэгч)
Гишүүд:	Г.Энхдэлгэр	(Эрүүл мэндийн төвийн эрхлэгч)
	Т.Уранчимэг	(Сургуулийн захирал)
	Э.Ванчиндорж	(Хэсгийн төлөөлөгч)
	М.Ганбуд	(Соёлын төвийн эрхлэгч)
	Д.Мандахцацрал	(Байгаль орчны улсын байцаагч)
	Д.Билгүүн	(Ган-Илч ХХК-ийн эрхлэгч)
	М.Найдан	(ШҮЗТехникч)
	Э.Эрдэнэчимэг	(Ус цаг уур өртөөний техникч)
	Б.Өлзийбат	(Улсын нөөцийн нярав)
	Л.Батбаатар	(4-р багийн засаг дарга)